



**МОНГОЛ УЛСЫН  
ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН  
ЯАМ**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,  
Утас: 26-22-71, Факс: (976-11) 45-31-21,  
E-mail: mofa@mofa.gov.mn; http://www.mofa.gov.mn

2013.10.14 № 01/3937

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН  
БАЙНГЫН ХОРООНД**

Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд тус яамнаас гаргах мэдээ, мэдээллийг хуваарийн дагуу хүргүүлж байна.

Хавсралт: 8 . хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Х.ЗОЛЖАРГАЛ

0000004582

УЛСЫН ИХ ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АСУУДАЛ,  
САЙДЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН  
АСУУДЛЫН МЭДЭЭЛЭЛ

Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамнаас “Малын генетик нөөцийн тухай хууль”-ийн төсөл, “Малын эрүүл мэндийн тухай хууль”-ийн төсөл, “Органик хүнсний тухай хууль”-ийн төслийг тус тус Улсын Их Хурлын намрын чуулганаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн Сайдын зөвлөлийн хуралдаанаар:

1. 2013 оны ургацын баланс, буудай, гурилын хангамж;
2. Арьс, ширний салбарт хэрэгжүүлж буй арга хэмжээний явц, цаашдын чиг хандлагын талаарх танилцуулга;
3. Төмс, хүнсний ногоо хөтөлбөр;
4. Тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг батлах тухай Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын тушаалын төслийг тус тус хэлэлцлээ.

МАХНЫ ХАНГАМЖ НӨӨЦИЙН ТАЛААРХ МЭДЭЭ

Монгол банкны Ерөнхийлөгч, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын хамтарсан А-166/А-24 дугаартай тушаалаар батлагдсан “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/272 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2014 онд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын хэрэгцээнд нөөцийн мах бэлтгэн, нийлүүлэх менежерийг сонгон шалгаруулах НММСШ/2014/01 дугаар, НММСШ/2014/02 дугаар төслүүдэд ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн төсөлд үнэлгээ хийж, сонгон шалгаруулаад байна.

Шалгаруулалтаар махны нөөц бүрдүүлэх, хадгалах, ангилан савлах, худалдаалах үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий “Нөөцийн махны менежер”-ээр төслийн 1 дүгээр багцын Улаанбаатар хотын 6000 тн махыг “Эи Эн Ди Эм” ХХК, 2 дугаар багцын Улаанбаатар хотын 6000 тн махыг “Баатарууд тэнгэр” ХХК, 3 дугаар багцын Дархан хотын 1000 тн махыг “Дархан мийт фүүд” ХХК, 4 дүгээр багцын Эрдэнэт хотын 1000 тн махыг “Эрдмийт” ХХК-тай тус бүр гэрээ байгуулан ажиллахаар бэлтгэж байна.

ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНААР 2013 ОНД ХЭЛЭЛЦҮҮЛЭХ  
АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

/2013 оны III улирлын байдлаар/

№	Хэлэлцүүлэх асуудлын агуулга	Төлөвлөсөн огноо	Хэрэгжилт		Тайлбар
			Хэлэлцүүлсэн огноо	Шийдвэрийн дугаар	
1.	Малчдын хоршоог дэмжих зарим арга хэмжээний тухай /Засгийн газрын тогтоолын төсөл/	2013.1.12	2013.1.12	Дугаар 8	
2.	Улсын сайн малчин, улсын тэргүүний малчдын бүлэг, улсын тэргүүний фермер шалгаруулах тухай /Засгийн газрын тогтоолын төсөл/	2013.1.19	2013.1.12	Дугаар 13	
3.	“Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор” төслийн санхүүжилтийн тухай /Засгийн газрын тогтоолын төсөл/	2013.1.26	2013.3.2	Дугаар 76	
4.	Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай /Засгийн газрын тогтоолын төсөл/	2013.1.26	2013.1.19	Дугаар 22	
5.	Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөрийн бодлогын зөвлөл байгуулах тухай /Засгийн газрын тогтоолын төсөл/	2013.1.26	-	-	Төсөлд яамдын саналыг тусгаж, ЗГХЭГ-т хүргүүлэхээр бэлтгэж байна.
6.	Журам батлах тухай /Арьс ширний үндэсний үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл олгох журам/ /Засгийн газрын тогтоолын төсөл/	2013.2.2	2013.2.7	Дугаар 48	
7.	Арьс ширээ үндэсний боловсруулах үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд урамшуулал олгох журам /Засгийн газрын тогтоолын төсөл/	2013.2.2	2013.2.7	Дугаар 48	
8.	Нүүрс шингэрүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай. /Засгийн газрын хуралдааны тэмдэглэл/	2013.2.9	2013.7.6	Дугаар 246	
9.	Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд урамшуулал олгох журам /мал, сүү/ /Засгийн газрын тогтоолын төсөл/	2013.2.9	2013.3.2	11 дүгээр тэмдэглэл	Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу хойшлуулав.
10.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2013.2.9	2013.2.2	7 дугаар тэмдэглэл	Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу хойшлуулав.
11.	Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн дүрэм, ажиллах журам батлах тухай /Засгийн газрын тогтоолын төсөл/	2013.2.9	2013.3.2	Дугаар 78	

12.	Хөдөө аж ахуйн бирж компани байгуулах тухай /Засгийн газрын тогтоолын төсөл/	2013.2.23	2013.1.26	Дугаар 30	
13.	Боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх эрх зүйн орчин, тэргүүн ээлжинд дэмжих төслийн жагсаалт, боловсруулах үйлдвэрийн байрлал, чиглэл батлах тухай. /Засгийн газрын тогтоолын төсөл/	2013.2.23	-	-	Төсөлд яамдын саналыг авч тусган, эцэслэн боловсруулж байна. 11 дүгээр сард багтаан хэлэлцүүлэхээр ажиллаж байна.
14.	Хүнсний ногоо хөтөлбөр батлах тухай /Засгийн газрын тогтоолын төсөл/	2013.2.23	2013.4.27	19 дүгээр тэмдэглэл	“Төмс, хүнсний ногоо” гэж өөрчлөн, дахин хэлэлцүүлэхээр хойшлуулав. Төслийг 9 сарын 18-нд ҮХАА-н сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, саналыг тусгаж, яамдаас санал авахаар ажиллаж байна.
15.	Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх тухай /Засгийн газрын тогтоолын төсөл/	2013.2.23	2013.2.2	Дугаар 39	
16.	Гаалийн албан татварын тухай болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай. /Нүүрс шингэрүүлэх үйлдвэрийн тоног төхөөрөмжийг гааль, НӨАТ-аас чөлөөлөх/	2013.2.23	-	-	Уул, уурхайн яамнаас асуудлыг хэлэлцүүлж, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.
17.	Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журам /Засгийн газрын тогтоолын төсөл/	2013.2.23	2013.3.2	11 дүгээр тэмдэглэл	Засгийн газрын гишүүдээс гар-гасан саналын дагуу хойшлуулав. Төслийг дахин боловсруулж, аймаг, нийслэлийн Засаг дарга, яамдаас саналыг авч нэгтгэн, Засгийн газарт хүргүүлэхээр ажиллаж байна.
18.	Мал аж ахуйн хаваржилтийн нөхцөл байдлын талаар танилцуулга /Засгийн газрын хуралдааны тэмдэглэл/	2013.3.16	2013.03.30	Дугаар 113	
19.	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	2013.3.23	-	-	Төслийг боловсруулж байна.
20.	Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай /УИХ-ын тогтоолын төсөл/	2013.3.30	2013.2.2	7 дугаар тэмдэглэл	УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов.
21.	Таримлын сэлгээ хөтөлбөр батлах тухай /Засгийн газрын тогтоолын төсөл/	2013.4.6	2013.4.27	19 дүгээр тэмдэглэл	ҮХААЯ мэргэжлийн үндсэн дээр зохицуулах нь зүйтэй гэж үзэж, уг хөтөлбөрийг Засгийн газраас батлах шаардлагагүй гэж тогтов.
22.	Стратегийн хүнсийг экспортлох, импортлоход зөвшөөрөл олгох тухай журам /Засгийн газрын тогтоолын төсөл/	2013.4.20	2013.3.2	Дугаар 77	



23.	Төрийн өмчийг 2012-2016 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай /УИХ-ын тогтоолын төсөл/	2013.4.20	2013.6.8	28 дугаар тэмдэглэл	Хувьчлал, өөрчлөн байгуулах аж ахуйн нэгжүүдийг салбар, салбараар төрөлжүүлэн ярилцаж тохирсны дараа дахин хэлэлцэхээр хойшлуулсан.
24.	Мал аж ахуйн хөгжлийн тухай хуулийн төсөл	2013.4.27	-	-	Судалгаа хийж, мал аж ахуйн үйлдвэрлэлийн харилцаанд оролцогч 813 иргэнээс санал, асуулга авлаа. Хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төслийн анхны хувилбарыг боловсруулж, байна.
25.	Хаврын тариалалтын бэлтгэл хангасан дүнгийн танилцуулга /Засгийн газрын хуралдааны тэмдэглэл/	2013.5.4	2013.5.25	25 дугаар тэмдэглэл	
26.	Махны үйлдвэрлэл худалдаанд мөрдөх махны техникийн зохицуулалт /Засгийн газрын тогтоолын төсөл/	2013.5.25	-	-	МХЕГ-ын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт хийж байгаагаас шалтгаалж, асуудлыг хэлэлцүүлэхээс түр хойшлуулаад байна.
27.	Тариалалтын эцсийн дүн /Засгийн газрын хуралдааны тэмдэглэл/	2013.6.29	2013.7.6	32 дугаар тэмдэглэл	
28.	Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай /Засгийн газрын тогтоолын төсөл/	2013.7.6	2013.7.9	Дугаар 266	
29.	Тариалангийн багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	2013.8.10	-	-	Хуулийн төслийг боловсруулж байна.
30.	Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн бүтэц үйл ажиллагааг төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн харилцан түншлэлийн оролцоотой корпораци болгон зохион байгуулах тухай /Засгийн газрын тогтоолын төсөл/	2013.8.10	-	-	Төрийн өмчийг 2012-2016 онд хувьчлах үндсэн чиглэл батлагдасны дараа хэлэлцүүлэхээр түр хойшлуулаад байна.
31.	Махны улирлын нөөц бүрдүүлэх асуудлаар танилцуулга /Засгийн газрын хуралдааны тэмдэглэл/	2013.8.17	-	-	2013 оны 8 дугаар сард Ерөнхий сайдад танилцуулга хийсэн.
32.	Ургацын урьдчилсан балансын танилцуулга /Засгийн газрын хуралдааны тэмдэглэл/	2013.8.24	2013.8.24	-	Засгийн газрын тэмдэглэлийг одоогоор хүлээж аваагүй байна.

**ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ 2013 ОНД  
ХИЙГДЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ЯВЦЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Төрөөс үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарын талаар баримталж буй бодлогыг хэрэгжүүлэх, Монгол Улсыг үйлдвэржүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, үйлдвэрүүдийг чанарын баталгаатай түүхий эдээр хангах зорилгоор “Монгол улсын 2013 оны төсвийн тухай” хуулиар нийт 42 арга хэмжээг 77,7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр батлагдсан байна. Үүнээс худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар орон нутагт 11 арга хэмжээг, Худалдан авах ажиллагааны газарт 16 арга хэмжээг, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яаманд 15 арга хэмжээг тус тус хуваарилагдсан байна.

/сая төгрөг/

Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүч чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2013 онд санхүүжих	Гүйцтгэл	Хэрэгжилт
XXYIII	ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД			160 489,0	77 737,6	16 803,1	
XXYIII.1	Хөрөнгө оруулалт:			86 812,2	30 053,0	5 589,8	
	Шилжих:			81 922,2	25 163,0	4 422,8	
XXYIII.1.1	Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон хөдөөгийн амьжиргаа" төслийн дотоод эх үүсвэр	2012	2016	3 917,2	100,0		Монгол Улсын засгийн газрын оролцооУлсын төсвийн хөрөнгө 100,0 сая Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн хөрөнгө 515,2 сая нийт 615,2 сая төгрөгөөр инженерийн хийцтэй 28 худаг шинээр гаргах 4 худаг сэргээн засварлах ажлын гүйцэтгэгчээр "Танан импекс" ХХК, "Гранд электро техноком" ХХК-ууд шалгалсан. Инженерийн хийцтэй худгийг барьж байгуулах ажил хийгдэж дууссан 10-р сард гүйцэтгэл ирснээр санхүүжилт гарна.
XXYIII.1.2	Хүнсний лаборатори байгуулах /Улаанбаатар/	2012	2013	4 300,0	3 138,0	505,8	2012 оны төсвийн тухай хуулиар тус лабораторийг байгуулах төсөвт өртөг 4,3 тэрбум төгрөг батлагдан 2012 онд төсөвт өртгөөр тендер зарлан шалгарсан Медимпекс ХХК-тай гэрээ байгуулан урьдчилгаа санхүүжилт 1,1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. 2013 онд гэрээ дүгнэсэн акт үйлдэгдсэнээр үлдэгдэл санхүүжилтийг олгоно. 2013 оны 6 дугаар сард эхний ээлжийн тоног төхөөрөмжийг хүлээн авсан. Гэрээний хугацаа болоогүй, ажил хийгдэж байна
XXYIII.1.3	Хөдөөгийн хүн ам, мал аж ахуй, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах /Бүх аймагт/	2011	2015	26 584,0	7 000,0	371,9	Инженерийн хийцтэй худаг гаргах худалдан авах ажиллагааг орон нутагт зохион байгуулахаар эрхийг аймгийн засаг дарга нард шилжүүлсэн байна. Худаг гаргах хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулаад байна. Орон нутагт инженерийн хийцтэй 407 худаг гаргана, худаг гаргах хайгуул судалгааны ажил гүйцэтгэж 417 цэг тогтоох гэрээ байгуулагдсан
XXYIII.1.4	Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2012	2013	650,0	425,0		Барилга, байгууламжийн угсралтын ажлын гэрээг тендерт шалгарсан "Ди Си Эйч" ХХК-тай гэрээ байгуулсан барилга угсралтын ажил гэрээнд зааснаар 11-р сард дуусна.
XXYIII.1.5	Малын удмын сангийн үндэсний цогцолбор /Дархан-Уул, Хонгор/	2012	2015	12 271,0	5 500,0	3 460,2	"Малын удмын сангийн үндэсний цогцолбор"-ын ажлыг гүйцэтгэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах ажлыг Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулсан байна. "Набсан" ХХК-тай гэрээ байгуулсан барилга угсралтын ажил эхэлсэн.
XXYIII.1.6	Түүхий эд, бүтээгдэхүүний бирж байгуулах, түүхий эдийн агуулах байгуулах /Улаанбаатар, бүх аймгууд/	2012	2013	5 000,0	5 000,0	34,9	Засгийн газрын 30 дугаар тогтоолоор "Хөдөө аж ахуйн бирж" төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулан биржийн арилжааг эхлүүлээд байна. ЗГ-ын 2013 оны 30 дугаар тогтоолоор "Хөдөө аж ахуйн бирж" Төрийн өмчит хуулийн этгээдэд оруулах хөрөнгөд шилжүүлэх шийдвэрийг гаргавулсан ажил хэвийн явагдаж байна.



XXYIII.1.7	Бэлчээр усжуулах зорилгоор гүний өрмийн худагт салхин сэснэн шахуурга суурилуулах /Дорноговь, Говьсүмбэр/	2012	2013	200,0	200,0	50,0	Дорноговь, Говьсүмбэр аймгуудын 15 худагт салхин сэснэн шахуурга суурилуулах тендер зарлан гүйцэтгэгчээр "Хан мокор" ХХК шаргаран гэрээт ажил хэвийн үргэлжилж байна.
XXYIII.1.8	Хилийн боомтуудад ариутгал халдваргүйтлийн байгууламж байгуулах (Монгол мал үндэсний хөтөлбөр)	2012	2017	29 000,0	3 800,0		Хилийн боомтуудад ариутгал халдваргүйтлийн байгууламж байгуулах ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан гэрээ байгуулах шатандаа явагдаж байна
	Шинэ:			4 890,0	4 890,0	1 167,0	
XXYIII.1.9	Буянт голын услалтын систем /Ховд/	2013	2013	2 000,0	2 000,0	556,0	"Буянт голын услалтын систем"-ийн ажлыг гүйцэтгэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах ажлыг Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулсан байна. Гүйцэтгэгчээр "Монгол менежмент төв" ХХК шалгаран ажил хуваарийн дагуу хийгдэж байна.
XXYIII.1.10	Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж /Ховд/	2013	2013	2 000,0	2 000,0		"Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж"-ийн ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг Ховд аймгийн засаг даргад шилжүүлсэн байна.
XXYIII.1.11	Аймгийн хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын барилга /Сүхбаатар, Баруун-Урт/	2013	2013	890,0	890,0	611,0	2012 онд барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж "Хатан туул хөгжил" ХХК-тай гэрээ байгуулсан 2013 онд барилгын ажил бүрэн дуусна
XXYIII.2	Их засвар:			1 998,8	1 520,6	325,5	
XXYIII.2.1	Мал эмнэлгийн лабораторийн засвар /Булган, Өвөрхангай/	2013	2013	55,0	55,0		Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газарт худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг шилжүүлсэн Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарт худалдан авах ажиллагаанд хяналт байна. Орон нутагт тендер шалгаруулалт хийгдэн гэрээ байлан гүйцэтгэл ирүүлснээр санхүүжилт хийгдэнэ.
XXYIII.2.2	Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын засвар /Говь-Алтай, Дорнод/	2013	2013	30,4	30,4	15,3	
XXYIII.2.3	Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын засвар /Дорноговь/	2011	2013	99,8	54,8	54,3	
XXYIII.2.4	Мал эмнэлгийн лабораторийн засвар /Дундговь/	2011	2013	178,0	170,0		
XXYIII.2.5	Мал эмнэлгийн лабораторийн засвар /Завхан/	2011	2013	370,9	288,6	255,9	
XXYIII.2.6	Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар болон Мал эмнэлгийн лабораторийн засвар /Өмнөговь/	2013	2013	157,9	157,9		
XXYIII.2.7	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны 250 хүний суудалтай хурлын заалны засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2013	445,0	445,0		
XXYIII.2.8	Мал эмнэлгийн лабораторийн засвар /Сүхбаатар/	2011	2013	63,7	25,0		Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газарт худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг шилжүүлсэн Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарт худалдан авах ажиллагаанд хяналт байна. Орон нутагт тендер шалгаруулалт хийгдэн гэрээ байлан гүйцэтгэл ирүүлснээр санхүүжилт хийгдэнэ.
XXYIII.2.9	Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын засвар /Төв, Говьсүмбэр/	2013	2013	13,1	13,1		
XXYIII.2.10	Мал эмнэлгийн лабораторийн барилгын их засвар /Хэнтий/	2013	2013	50,0	50,0		
XXYIII.2.11	Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын их засвар /Дархан-Уул/	2011	2013	185,0	150,0		
XXYIII.2.12	Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын төв /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2012	2013	350,0	80,8		Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын төвийн засварын зураг төсвийн ажил хийгдэж дууссан. Засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна
XXYIII.3	Тогог төхөөрөмж:			3 819,0	2 554,0	523,6	
XXYIII.3.1	Мал эмнэлгийн ариутгал халдваргүйтлийн арга хэмжээг хэрэгжүүлэх, өвчтэй малыг халдвар дамжуулахгүйгээр нядлах тоног төхөөрөмж /Монгол мал үндэсний хөтөлбөр/	2011	2013	1 200,0	1 200,0		Ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлыг зохион ажлыг зохион байгуулсан гэрээ байгуулах шатандаа явагдаж байна
XXYIII.3.2	Хөнгөн үйлдвэрийн салбарт нано биотехнологи нутагшуулах	2012	2013	500,0	250,0		Хөнгөн үйлдвэрийн салбарт нано биотехнологи нутагшуулах тендерийг Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулан ажиллаж байна.



ХХҮШ.3.3	Үйлдвэр, хөдөө аж ахуйн байгууллагуудын тоног, төхөөрөмжийн шинэчлэл	2012	2013	2 030,0	1 015,0	438,4	Үйлдвэр, хөдөө аж ахуйн байгууллагуудын тоног, төхөөрөмжийн шинэчлэл хийхээр тендер зарлан шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуусан байна. 2013 оны 07 сард тоног төхөөрөмж нийлүүлэгдэнэ.
ХХҮШ.3.4	Төрийн өмчийн хорооны тоног төхөөрөмж	2013	2013	89,0	89,0	85,2	Төрийн өмчийн хорооны тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхээр тендер зарлан шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна
ХХҮШ.4	Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл:			15 410,0	15 410,0	85,7	1%
ХХҮШ.4.1	Аймгийн мал эмнэлгийн барилга шинээр барих техник эдийн засгийн үндэслэл боловсруулах /Баянхонгор/	2013	2013	20,0	20,0		2013.02.26-ны өдөр тендерийг зарлаж, 2013.03.11 өдөр хугацаа дууссан. Нэг ч мэдүүлэг ирээгүй учир 2013.03.27 өдөр дахин зарлаж 2013.04.15 өдөр мэдүүлэг хүлээж авч дууссан. Зарлалын дагуу 2 компани мэдүүлэг ирүүлсэнээр Худалдан авах ажиллагааны газраас гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан байна.
ХХҮШ.4.2	Үйлдвэр технологийн парк байгуулах судалгаа, зураг төсөл, био-технологийн лабораторийг чадавхижуулах, Нано технологийн төв болон лаборатори байгуулах техник эдийн засгийн үндэслэл боловсруулах	2013	2013	590,0	590,0	85,7	Орон нутагт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах зураг, төсөл, ТЭЗҮ боловсруулах гэрээг "Бегофарбен" ХХК-тай, Ноос, ноолуурын салбарын ҮТПарк байгуулах судалгаа, ТЭЗҮ боловсруулах гэрээг "Цагчигт-цогц" ХХК-тай, Модны салбарын цогцолбор ҮТПарк байгуулах судалгаа, ажлын зураг ТЭЗҮ боловсруулах гэрээг "Ой модны үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо"-той, Арьс ширний лабораторийг чадавхижуулах судалгаа, ТЭЗҮ боловсруулах гэрээг "Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнтэй тус тус байгуулан ажиллаж байна
ХХҮШ.4.3	Нийслэл хотод хоногт 5-аас доошгүй тн сүү хүлээн авч нярай хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэр байгуулах техник эдийн засгийн үндэслэл боловсруулах /Улаанбаатар/	2013	2013	50,0	50,0		Үнэлгээний хороо дахин хуралдаж зарлалын хугацааг сунгаж 4-р сарын 16-нд дахин зарласан. 4-р сарын 26-ныг хүртэл мэдүүлэг хүлээж авсан. Хураангуй жагсаалтанд орсон 5 компанид саналын урилга хүргүүлэн ирүүлсэн саналд үнэлгээ хийгдэж байна.
ХХҮШ.4.4	Загасны үйлдвэр байгуулах техник эдийн засгийн үндэслэл боловсруулах /Завхан, Архангай, Говь-Алтай, Ховд, Хөвсгөл/	2013	2013	50,0	50,0		Үнэлгээний хороо 2013.04.15-д хуралдсан. Хураангуй жагсаалт үүсгэсэн. Саналын урилгыг 4-р сар 15-нд хүргүүлсэн. Худалдан авах ажиллагааны газар гүйцэтгэчийг сонгон шалгаруулж "Солорхаус" ХХК-тай гэрээ байгуулсан ажил хуваарийн дагуу хийгдэж байна
ХХҮШ.4.5	Таримал ургамлын элит үр үржүүлэг, шинэ сортыг бий болгох, нутагшуулах, сорт сорилт, судалгааны ажлыг эрчимжүүлж, үрийн чанар хангамжийг сайжруулах;	2013	2013	3 000,0	3 000,0		"Таримал ургамлын үр үржүүлэг, таримлын сэлгээ, шинэ сортуудыг сорих, нутагшуулах, сорт сорилтын төвүүдийн үйл ажиллагааг сэргээх зөвлөх үйлчилгээ"-ний гэрээг Монголын хөдөгөг шинэчлэх фермерүүдийн холбоотой, "Алслагдсан бүсэд газар тариаланг сэргээн хөгжүүлэх" ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээ"-ний гэрээг Монголын хөдөгөг шинэчлэх фермерүүдийн холбоотой, "Үр тариа, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл, нийлүүлэлтийн хэлхээн дэхь логистик урсгалын судалгаа" зөвлөх үйлчилгээний гэрээг Монголын логистикийн холбоото тус тус байгуулсан
ХХҮШ.4.6	Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах бэлтгэлийг хангах, нүүрснээс шингэн түлш, хий гаргах үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах	2013	2013	2 900,0	2 900,0		Ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлыг Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж байна
ХХҮШ.4.7	Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор болон Багануур, Дарханы үйлдвэр технологийн паркийн захиргаа байгуулах, ерөнхий төлөвлөгөө боловсруулах /Дорноговь, Улаанбаатар, Дархан-Уул/	2013	2013	8 700,0	8 700,0		Багануур, Дарханы үйлдвэр технологийн паркийн захиргаа байгуулах, ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын зарыг 2013.04.19 тавьсан. Ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлыг Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж байгаагаас "Сайншанд аж үйлдвэрийн цогцолборын газар доорхи усны нарийвчилсан хайгуулын ажил" хийх гэрээг "Түнгалаг үс" ХХК-тай байгуулсан байна.
ХХҮШ.4.8	Зүүн бүсийн холимог металлын ордын түүхий эдийг боловсруулах үйлдвэр байгуулах судалгаа	2013	2013	100,0	100,0		2013 оны 05 дугаар сарын 13-ны өдөр тендер зарлагдсан Ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлыг Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж байна
ХХҮШ.5	Хөрөнгийн шилжүүлэг, дэмжлэг			52 449,0	28 200,0	10 278,5	



XXYIII.5.1	Газар тариалангийн бүтээгдэхүүний агуулах байгуулах /Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Булган, Улаанбаатар, Увс, Хөвсгөл, Дорнод/	2012	2013	20 500,0	10 500,0	2 054,7	Газар тариалангийн бүтээгдэхүүний агуулах байгуулах 10,5 сая төгрөгөөс 2012 оны тендерийн үлдэгдэл санхүүжилтэд 6,4 тэрбум төгрөгийг хуваарилаж, 4,1 тэрбум төгрөг төсөвлөж Дархан-Уул аймагт ТЭДС-ийн агуулахын цогцолбор байгуулах ажлыг 3725,8 сая төгрөгөөр хийж гүйцэтгэгчээр Батширээт ХХК шалгарч гэрээ байгуулсан байна
XXYIII.5.2	Услалтын системийг сэргээн засварлах, шинээр барих /Зураг төсөв нь хийгдсэн усалгаатай тариалан эрхлэх боломжтой бүс нутагт/	2012	2013	6 800,0	6 800,0	1 761,4	Услалтын системийг сэргээн засварлах, шинээр барихаар 6,8 тэрбум төгрөгөөс 2012 оны тендерийн үлдэгдэл санхүүжилтэд 2,9 тэрбум төгрөгийг хуваарилаж, 3,9 тэрбум төгрөгөөр Төрийн болон орон нутгийн өмчийн услалтын системийг шинээр барих, сэргээн засварлах болон Усалгаатай тариалан, хадланд тохиромжтой талбайн хайгуул судалгаа хийх, төрийн ба орон нутгийн өмчийн услалтын системийн зураг төсөл зохиох зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулан ажиллаж байна
XXYIII.5.3	Өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх /Дархан-Уул, Орхон, Улаанбаатар/	2011	2013	3 000,0	1 000,0		Ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж байна
XXYIII.5.4	Сум дундын загвар нядалгааны цех байгуулахад дэмжлэг үзүүлэх	2013	2013	400,0	400,0		Сум дундын загвар нядалгааны цех байгуулах ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулан "Немон"ХХК-тай гэрээ байгуулсан байна.
XXYIII.5.5	Төмс, хүнсний ногоо, тариалангийн техникийн шинэчлэл	2012	2013	7 000,0	6 000,0	4 978,8	2012 оны тендерийн үлдэгдэл санхүүжилтэд 3,5 тэрбум төгрөгийг хуваарилаж, 2,5 тэрбум төгрөгөөр Төмс, хүнсний ногоо үйлдвэрлэлийн зориулалттай бага оврын техник, тоног төхөөрөмж болон Хүнсний ногооны үрслэг суулгах зориулалттай машин худалдан авах тендерийг Худалдан авах ажиллагааны газар шалгаруулж шалгарсан "Мөнх ногоон тал" ХХК, "Агро трейд импекс" ХХК, "Сонг Ху Ти Эс" ХХК-уудтай гэрээ байгуулаад байна. Ажил хувьцарийн дагуу хийгдэж байна
XXYIII.5.6	Хүнсний ногооны хүлэмжийн аж ахуй байгуулах	2012	2013	1 000,0	1 000,0	483,8	2012 оны тендерийн үлдэгдэл санхүүжилтэд 484,0 сая төгрөгийг хуваарилаж, 516,0 сая төгрөгөөр 240 м2 талбай бүхий нийлэг хальсан хүлэмж болон Гүзээлзгэнэ тарихад зориулагдсан 1050 м2 талбайтай, автомат ажиллагаатай, давхар хүлэмж худалдан авхаар тендер шалгаруулж шалгарсан "Мөнх ногоон тал" ХХК-тай гэрээ байгуулаад байна. Ажил хувьцарийн дагуу хийгдэж байна
XXYIII.5.7	Малын тэжээлийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж (Эрчимжсэн мал аж ахуй эрхэлж буй аймаг, сум, хот суурин газрууд)	2012	2017	13 749,0	2 500,0	999,9	Хүчит тэжээлийн цех, Ногоон тэжээл үйлдвэрлэх тоног төхөөрөмж, Өвс хуйлж боох хаман боогч техник худалдан авах тендер зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулан "Тэнүүн хас"ХХК, "Нью фоос"ХХК-уудтай гэрээ байгуулсан байна. Ажил хуваарийн дагуу хийгдэж байна.